**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/111 Биндэр сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа
Хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн
нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан газрыг 1 дүгээр хавсралтад дурдсан 1 иргэнд 2035м$^2$ газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 92 дугаар захирамжийн 10 хэсгийг хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Газраа шилжүүлсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

D:/My document/Захирамж төсөл 2026

Сумын Засаг даргын 2026 оны 07 дугаар сарын 03 -ны өдрийн А/111 тоот захирамжийн хавсралт

| Д/д | Өмчлөх эрхээ шилжүүлэн авч байгаа иргэний | | | | Хамтран өмчлөлөөс хасуулж байгаа иргэний | | | | Захирамжийн | | | | Өмнөх газрын | | Одоо газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Хуучин нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Байршил, хаяг | Шинэ нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ |
| 1 | Хошууд | Монхор | Сарантуяа | СЖ80111204 | Сартуул | Шийтэр | Бямбажаргал | ХЙ77123118 | 2012,12,11 | 92 | 1 | 10 | 220700798 | 1148 | Худалдаа-3 301 тоот | | 2035 |
| | | | | | Сартуул | Бямбажаргал | Бат-Эрдэнэ | УП03271251 | | | | | | | | | |
| | | | | | Сартуул | Бямбажаргал | Батжавхлан | УЦ04312431 | | | | | | | | | |